



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 11 өдөр

Дугаар A/80.

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
2. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Шанш ХХК-ийн "Хантерс" дэн буудлын 15/026 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцугай
4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.
5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА



E:\NAJG\Alban\blanknii\helvlelt\Tushaal\A\16.08.11.A80.docx

1150500214

Нийслэлийн Аллая жуулчлалын газрын
даргын 2016 оны 08 сарын 11 өдрийн
A/80 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.08.11

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Шанш ХХК	Хантерс	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Доржийн гудамж 48 б
2	Би Би Эйч Эйч ХХК	Ивээл	Сонгинохайрхан дүүрэг, 13-р хороо, 198/1

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 08 сарын 11 өдрийн
A/80 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

УОА8453

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.08.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Омега ХХК	Номун	Сүхбаатар дүүрэг, 20-р хороо, Сэлбийн зуслан

-ооОо-